

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТЭШИГ УС” ОНӨААТҮГ-ЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА/2020/05-ГА

Үйл ажиллагаа болон санхүүгийн
төлөвлөгөөг алдагдалтай тооцоолж
батлуулсан, өглөгийг нэмэгдүүлж
алдагдалтай ажилласан нь
байгууллагын үйл ажиллагаанд
тавих дотоод хяналт сул, үр дүн
бага байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгтийн товъёг.....

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

БҮЛЭГ А. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын төлөвлөлт үр нөлөө бага байна.....7

А.1. “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулж ажилласан ч үйл ажиллагааны зардлыг нийт орлогоос 7368.5 мянган төгрөгөөр алдагдалтай ажиллахаар батлуулсан байна.....7

А.1.1 “Тэшиг Ус” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулсан боловч ТУЗ-ийн даргыг сарын 950.0 мянган төгрөгөөр цалинжуулахаар төлөвлөн батлуулсан нь ТӨОХЭТӨТ-ийг тухай хуулийн 3.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.....7

А.1.2 Байгууллагын зорилго, зорилтын түвшинд хүрч ажилласан байна.....7

А.1.3 Сумын ИТХ-аар ОНӨААТҮГ-ын дүрмийг батлуулжээ.....7

А.1.4 Бүтэц орон тооны хувьд оновчтой батлуулаагүй, үйл ажиллагааны нийт зардлын 57 хувь буюу 129912.1 мянган төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан байна.....8

А.2 Орлогын бүрдүүлэлт, ХАА-ны төлөвлөлт хийж ажилласан ч дулаан үйлдвэрлэлийн орлого 8 хувиар тасарсан үзүүлэлтэй байна.....8

А.2.1 “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын орлогын бүрдүүлэлт төлөвлөсөн орлогоос 22132.8 мянган төгрөгөөр тасарчээ.....8

А.2.2 Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөө батлуулж ажилласан байна.....8

Б. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүн бага, гэрээ хийгээгүй газраас нүүрсний худалдан авалт хийсэн, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, авлагыг дутуу тооцсон зөрчлүүд илэрч байна.....8

Б.1 Санхүүгийн төлөвлөгөөг 7368.5 мянган төгрөгийн алдагдалтайгаар батлуулсан байна.....8

Б.1.1 Жилийн орлого, зарлагыг төлөвлөн батлуулж ажилласан ч 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.....8-9

Б.1.2 Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч ТУЗ-ын даргыг 5842.6 мянган төгрөгөөр цалинжуулсан байна.....9

Б.1.3 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээ, тайланг үнэн зөв, хугацаанд нь мэдээлж ажиллажээ.....9

Б.1.4 Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаж, харилцагч байгууллага иргэдтэй тооцоо нийлж ажилласан ч авлагыг 400.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.....9-10

Б.1.5 Шинээр 22739.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг хийжээ..10

Б.2 ХАА-г бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ хийж ажилласан боловч гэрээ хийгээгүй газраас нүүрсний худалдан авалт хийсэн байна.....10

Б.2.1 Бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллажээ.....10

Б.2.2 Гэрээний дагуу гүйцэтгэгч нүүрс нийлүүлж ажилласан байна.....10-11

Б.2.3 Гүйцэтгэгч компани руу 27428.4 мянган төгрөгийг шилжүүлжээ.....11

Б.3 Дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж үр дүнг тооцож ажилласан байна.....11

Б.3.1 ТУЗ-ын гишүүдийг 2018 онд шинэчлэн сонгож ажиллажээ.....11

Б.3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажилласнаар зарим зардал буурсан гэж үзэж байна.....11-12

Б.3.3 Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнаж, үүрэг даалгавар авч ажиллажээ.....12

ДҮГНЭЛТ.....	12
ЗӨВЛӨМЖ.....	12-13
МЭДЭГДЭЛ.....	13

Товчилсон үгийн тайлбар

ТТХ	Төсвийн тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨОХЭТӨТХЖ	Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам
ААНҮАТЗТХ	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Өглөгийг үлдээгдлийн харьцуулалт	10
Хүснэгт 2		
Хүснэгт 3		

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		
Зураг 2		
Зураг 3		
Зураг 4		
Зураг 5		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ. Аймгийн ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж бловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгднэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - ОНӨААТҮГ-ын ажлын төлөвлөлт үр нөлөөтэй байгаа эсэх. - ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүнтэй зарцуулагдсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий бусад байгууллага, аймаг сумын Засаг дарга, түүний харьяа байгууллага, гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа. Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа хийж гүйцэтгэлээ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 06 дугаар сарын 2-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 19-ны өдөр хүртэл ажлын 14 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	

А. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын төлөвлөлт үр нөлөө бага байна.

А.1. “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулж ажилласан ч үйл ажиллагааны зардлыг нийт орлогоос 7368.5 мянган төгрөгөөр алдагдалтай ажиллахаар батлуулсан байна.

А.1.1. “Тэшиг Ус” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулсан боловч ТУЗ-ийн даргыг сарын 950.0 мянган төгрөгөөр цалинжуулахаар төлөвлөн батлуулсан нь ТӨОХЭТӨТ-ийг тухай хуулийн 3.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

“Тэшиг Ус” ОНӨААТҮГ нь 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулахдаа дулаан үйлдвэрлэлийн орлогыг 265246.1, цэвэр бохир усны орлогыг 18500.0, нийт орлогыг 283746.1 мянган төгрөгөөр, 24 орон тоогоор, сарын цалингийн санг 14120.0, нийт зардлыг 291114.6 мянган төгрөгөөр төлөвлөж 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 тоот ТУЗ-ын тогтоолын хавсралтаар батлуулжээ

Жилийн төлөвлөгөөнд орон тоог 16 ажилчнаар шинэчлэн өөрчлөлт оруулж ТУЗ-ын 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 04 тоот тогтоолоор сарын цалингийн санг 9400.0 мянган төгрөгт багтаан гүйцэтгэхээр уг тогтоолыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсөн байна.

Тус газрын үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг дүгнэж үзэхэд ТУЗ-ын тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн даргыг сарын 950.0 мянган төгрөгийн цалин олгохоор тооцоолж жилд 11400.0 мянган төгрөг олгохоор баталсан нь ТӨОХЭТӨТ-ийг хэрэгжүүлэх тухай хуулийн 3.7 дахь заалтыг үндэслэж цалин авч байгаа боловч тус заалтад санхүү, эдийн засгийн байдал ашиг, орлогын үзүүлэлтийг харгалзан үзэж цалин урамшууллыг авч болно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн нийт үйл ажиллагааны зардлын задаргааг үзэхэд жилд орох орлогоосоо 7368.5 мянган төгрөгийн илүү буюу алдагдалтайгаар зардлыг тооцоолж батлуулсан нь төсвийг алдаатай буюу ашиггүй ажиллахаар тооцоолсон нь ажлын хариуцлагагүй, хяналт сул ажилласан байна.

Цаашид жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулахдаа нийт орлогод тулгуурлан орон тоог зөв хуваарилж нийт зардлыг оновчтой үр дүнтэй, ашигтай ажиллахаар судалж тооцоолсны үндсэн дээр төлөвлөн батлуулж байх шаардлагатай байна.

А.1.2. Байгууллагын зорилго, зорилтын түвшинд хүрч ажилласан байна.

Тус байгууллага нь сумын айл өрх, төсөвт байгууллага, аж ахуй нэгжийг дулаанаар хангах, ая тухтай орчинг бүрдүүлэхээр зорилго тавин ажиллажээ.

Зорилгын хүрээнд сумын төвийн төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг дулаан, цэвэр усаар бүрэн хангаж, засвар үйлчилгээг үзүүлэн ажилласан байна.

А.1.3. Сумын ИТХ-аар ОНӨААТҮГ-ын дүрмийг батлуулжээ.

Тэшиг сумын ИТХ нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.1.4 “ИТХ нь тухайн аймаг нийслэл, сум дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч байна.”, 77 дугаар зүйлийн 2.4 “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх байгуулах, татан буулгаж шийдвэр гаргаж хяналт тавих” гэсэн заалтыг үндэслэн 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 29 тоот сумын ИТХ-ын тогтоолоор байгуулан, байгууллагын дүрмийг 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн сумын ИТХ-ын 67 дугаар тогтоолоор анх батлуулж байсан байна. Үүнээс хойш байгууллагын дүрмийг ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 59 тоот тогтоолоор шинэчлэн баталжээ.

А.1.4. Бүтэц орон тооны хувьд оновчтой батлуулаагүй, үйл ажиллагааны нийт зардлын 57 хувь буюу 129912.1 мянган төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан байна.

Тус газар нь 2019 онд бүтэц орон тоог нийт 24 ажилтнаар батлуулан ажиллаж байгаад ТУЗ-ийн гишүүд хуралдан 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ын 04 тоот тогтоолоор 8 орон тоог хасаж 16 орон тоогоор ажиллахаар батлуулан ажиллажээ.

Жилийн эцэст нийт үйл ажиллагааны зардлын 57 хувь буюу 129912.1 мянган төгрөгийг цалингийн зардал эзэлж байгаа нь орон тоог оновчтой төлөвлөж зардлаа алдагдалтай тооцоолсноос үүсэж алдаа гарсан гэж үзэж байна.

Цаашид орон тоог оновчтой тооцоолж зардлыг хэмнэж ажиллах шаардлагатай байна.

А.2. Орлогын бүрдүүлэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт хийж ажилласан ч дулаан үйлдвэрлэлийн орлого 8 хувиар тасарсан үзүүлэлтэй байна.

А.2.1 “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын орлогын бүрдүүлэлт төлөвлөсөн орлогоос 22132.8 мянган төгрөгөөр тасарчээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2019 онд орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа дулаан үйлдвэрлэлийн орлогоос 265246.1, цэвэр бохир усны орлогоос 18500.0 мянган төгрөг буюу нийт 283746.1 мянган төгрөгийн орлого оруулахаас жилийн эцэст нийт 261704.3 мянган төгрөгийн орлого 22041.8 мянган төгрөгөөр тасалсан байна.

Үүнээс дулаан үйлдвэрлэлийн орлого 243212.5, цэвэр бохир усны орлого 18400.8 мянган төгрөгөөр тус тус орж дулаан үйлдвэрлэлийн 22033.6, цэвэр усны 99.2 мянган төгрөгийн орлого тус тус тасарчээ.

Орлого тасарсан шалтгаан нь зарим аж ахуйн нэгж байгууллага тогтмол үйл ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалсан гэж тайлбарлаж байгаа ч орлогын төлөвлөгөөг илүү төлөвлөснөөр илэрхийлэгдэж байна.

Цаашид өөрийн орлогыг нэмэгдүүлэхийн тул дуудлагаар засвар үйлчилгээ явуулж орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч инженер слесариудыг чадваржуулж ажиллах шаардлагатай байна.

А.2.2 Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөө батлуулж ажилласан байна.

Тус газар нь 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01 тоот ТУЗ-ын тогтоолын хавсралтаар бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг нээлттэй ба хязгаарлагдмал тендер шалгаруулалтад нүүрс, модны чиглэлээр 44600.0, шууд гэрээ байгуулж ажиллах 6 төрлийн бараа ажил үйлчилгээгээр 41290.0 мянган төгрөгөөр худалдан авалт хийхээр тус тус төлөвлөгөө боловсруулан батлуулжээ.

Б. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүн бага, гэрээ хийгээгүй газраас нүүрсний худалдан авалт хийсэн, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, авлагыг дутуу тооцсон зөрчлүүд илэрч байна.

Б.1 Санхүүгийн төлөвлөгөөг 7368.5 мянган төгрөгийн алдагдалтайгаар батлуулсан байна.

Б.1.1 Жилийн орлого, зарлагыг төлөвлөн батлуулж ажилласан ч 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-аар 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоолоор нийт орлогыг 283246.1 мянган төгрөгөөр, зарлагыг 291114.6 мянган төгрөгөөр төлөвлөн батлуулжээ.

Гүйцэтгэлээр нийт борлуулалтын орлогыг орлого үр дүнгийн тайлангаас үзэхэд тухайн онд 198921.7 мянган төгрөгийн орлого оруулж, үйл ажиллагааны зардалд 217581.9 мянган төгрөгийг зарцуулж 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаар тайлагнасан байна.

Тухайн онд орон тоог 24 ажилтнаар, мөн ТУЗ-ын дарга сар бүр 950.0 мянган төгрөгийн цалин авахаар батлуулсан зэрэг нь үйл ажиллагааны зарлагын төлөвлөлт болон өр зээлээ зөв тооцоололгүй, алдагдалтай төлөвлөж боловсруулжээ.

Цаашид үйл ажиллагаандаа зарцуулагдах зардлыг зөв тооцоолж хэмнэлттэй ажиллах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Б.1.2. Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч ТУЗ-ийн даргыг 5842.6 мянган төгрөгөөр цалинжуулсан байна.

Тус газар нь 2019 онд санхүүгийн төлөвлөгөөнд нийт зарцуулалтыг 291114.6 мянган төгрөгөөр батлуулж гүйцэтгэлээр 297538.8 мянган төгрөгийг зарцуулж дансанд 141.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Зардлын гүйцэтгэлийг түүвэрлэлтээр үзэхэд нүүрс модны зардалд 62802.2 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан зардлын хуваарилалтаас 19952.2 мянган төгрөгөөр илүү, бэлэн мөнгөний гүйлгээг хийсэн, кассын тайланг зөрүүтэй тайлагнасан, байгууллагын дарга ажилчдад нөхөн олговор олгох тухай тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж гаргасан, ХХОАТ-ыг суутган тооцоогүй, ТУЗ-ийн даргыг сар бүр 950.0 мянган төгрөгөөр тооцон нийт 5842.6 мянган төгрөгийг олгосон, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, аль зардлаас илүү зарцуулалт хийгдэж байгааг хянаж ажилладаггүй зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: Бэлнээр 59350.3 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн боловч нярав сар бүрийн тайланг хөтлөхдөө 60.0 мянган төгрөгийг хасаж тайлагнасан, 90.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг анхан шатны баримтгүй олгосон, шатахууны 54.3 мянган төгрөгийг түгээгчийн данс руу шилжүүлсэн нийт 204.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Шүүхийн шийдвэрийн 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 152/2019/00042/10 тоот тогтоолын дагуу 2765.4 мянган төгрөгийг байгууллагаас төлж барагдуулсныг Захиргааны ерөнхий хуулийн 103.1¹, 103.2² гэсэн заалтуудын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Цаашид батлагдсан зардлын дагуу зардлыг зарцуулж, төлөвлөгдөөгүй зардал гаргахгүй ажиллах шаардлагатай байна.

Б.1.3. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээ, тайланг үнэн зөв, хугацаанд нь мэдээлж ажиллажээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2019 онд жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг 23176.3, эргэлтийн бус хөрөнгийн үлэгдлийг 37627.2, нийт хөрөнгийн дүнг 60803.5 мянган төгрөгөөр тайлагнаж хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд санхүүгийн тайланг мэдээлж баталгаажуулан ажилласан байна.

Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай харьцуулахад эргэлтийн хөрөнгө 15051.4, эргэлтийн бус хөрөнгө 7367.5 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлтэй гарчээ. Буурсан үзүүлэлтийг бараа материал, үндсэн хөрөнгийн хасагдалтай холбоотой байна.

Б.1.4. Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаж, харилцагч байгууллага иргэдтэй тооцоо нийлж ажилласан ч авлагыг 400.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Тухайн онд авлагыг 11652.4 мянган төгрөгөөр бууруулж 7068.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өглөгийг 6084.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж оны эцэст 110115.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тус тус тайлагнасан байна.

Авлага өглөгийн дэлгэрэнгүйг хавсралт 1 хүснэгтээр харуулсан болно.


¹ “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”

² “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.

Жилийн эцэст харилцагч байгууллага, аж ахуй нэгж, иргэд, ажилчидтай тооцоо нийлж ажилласан гэх боловч ажилчдад олгосон цалингийн урьдчилгааны 400.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй, авлагаар тайлагнаагүй зөрчил илэрсэн тул төлбөрийн акт бичлээ.

Өглөгийн үлдэгдлийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд ажилчидтай оны эцэст тооцоо нийлж ажиллан нэр тус бүрээр нь гаргажээ.

Өглөгийн дүнг эзлэх хувиар харуулбал:



Байгууллага болон иргэдэд өгөх 58295.7 мянган төгрөгийн өглөг 60, татварт төлөх 37160.0 мянган төгрөгийн өглөг нийт 38, ажилчдад өгөх 1920.6 мянган төгрөгийн өглөг 2 хувийг тус тус эзэлж байна.

Цаашид өглөгийг бууруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Б.1.5 Шинээр 22739.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг хийжээ.

Тухайн онд тус байгууллага нь үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгээгүй, 22739.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан бүртгэлд бүрэн тусгаж тайлагнасан байна.

Б.2. Худалдан авах ажиллагааг бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ хийж ажилласан боловч гэрээ хийгээгүй газраас нүүрсний худалдан авалт хийсэн байна.

Б.2.1. Бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллажээ.

Тус газар нь 2019 онд нүүрс нийлүүлэлтийн худалдан авах гэрээг “Анд түрүүн” ХХК-тай 1тн нүүрсийг 77.0 мянган төгрөгөөр, “Мон ажнай” ХХК-тай 1 тн нүүрсний үнийг 88.4 мянган төгрөгөөр тус тус зээлээр нийлүүлэхээр 2019 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01, 04 тоот гэрээг тус тус байгуулан ажилласан байна.

Б.2.2. Гэрээний дагуу гүйцэтгэгч нүүрс нийлүүлж ажилласан байна.

Нүүрс нийлүүлэх гэрээ байгуулсан “Анд туруун” ХХК-иас 467 тн нүүрсийг 35959.0, “Мон Ажнай” ХХК-иас 258 тн нүүрсийг 34244.4 мянган төгрөгөөр тус тус худалдан авалт хийжээ.

Мөн нүүрсний 18853.4 мянган төгрөгийн анхан шатны нэхэмжлэх баримт дутуу, “Булган мээж” ХХК-иас 4000.0 мянган төгрөгийн нүүрс авсан гэх боловч иргэн Мөнхбаатарын тоот дансанд 3000.0, Чимгээгийн тоот дансанд 1000.0 мянган төгрөгийг

тус тус шилжүүлж ХХОАТ 400.0 мянган төгрөгийг тооцож ажиллаагүй, гэрээ байгуулж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Нүүрсний 18853.4 мянган төгрөгийг анхан шатны нэхэмжлэх баримтгүй баримтын бүрдэлт дутуу шилжүүлсэн нь НББ тухай хуулийн 13.1.³, 13.6.⁴, 13.7.⁵ дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага бичлээ.

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж худалдан авах гэрээ хийсэн аж ахуй нэгж иргэнээс худалдан авалт хийж байх шаардлагатай байна.

Б.2.3. Гүйцэтгэгч компани руу 27428.4 мянган төгрөгийг шилжүүлжээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь тухайн онд “Анд туруун” ХХК-иас 467 тн буюу 35.959.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авснаас жилийн эцсийн байдлаар 14400.0 мянган төгрөгийг шилжүүлэн 21559.0 мянган төгрөгийн өглөгтэй, “Мон Ажнай” ХХК-тай 2019 онд 258 тн нүүрс худалдан авч нийт 34244.4 мянган төгрөгийн өглөг үүссэнээс 27414.0 мянган төгрөгийг шилжүүлж жилийн эцэст 6830.4 мянган төгрөгийн өглөгтэйгөөр тус тус тайлагнасан байна.

Б.3 Дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж үр дүнг тооцож ажилласан байна.

Б.3.1 ТУЗ-ын гишүүдийг 2018 онд шинэчлэн сонгож ажиллажээ.

“Тэшиг ус” 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 29 тоот сумын ИТХ-ын тогтоолоор байгуулан, байгууллагын дүрмийг 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн сумын ИТХ-ын 67 дугаар тогтоолоор батлуулсныг шинэчлэн боловсруулж 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 49 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлуулан ажилласан байна.

Б.3.2 Байгууллагын зарим зардал тухайн жилд буурсан үзүүлэлтэйгээр дүгнэж байгаа боловч алдагдалтай буюу өглөг өр мянган төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан нь ТУЗ-ын дарга болон гишүүд дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 17/77 тоот байгууллагын даргын тушаалын хавсралтаар баталжээ.

Уг журамд заасны дагуу дотоод хяналтын ажилтан болон ТУЗ-ын гишүүд дотоод хяналт шалгалтыг хийж тоног төхөөрөмж, нүүрсний гэрээ, худалдан авалт, нөөц, өвлийн дулаалгын, төсөв, хөрөнгө, хүний нөөц, өмч хөрөнгийн талаар авч хэлэлцэн цаашид үүсэх эрсдэл болон алдаа дутагдалтай асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой үүрэг даалгавар өгч ажиллажээ.

Үүрэг даалгаврын дагуу ажилласнаар байгууллагын бүтэц орон тоог 2019 оны 11 дүгээр сард багасгаж цалингийн зардлыг 20, уурын зуух цэвэр усны станцын тоног төхөөрөмжийг шинэчлэн засварласнаар эвдрэл гэмтлийг 30 хувиар тус тус бууруулж ажилласан гэж үзсэн байна.

Байгууллагын тухайн жилд зарим зардал буурсан үзүүлэлтэй байгаа ч жилийн санхүүгийн тайлангаар дүгнэхэд өглөгийг 6084.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт өглөг 110115.7 мянган төгрөг болсон цаашид өглөгийг барагдуулах, ашиг алдагдлыг бууруулах тал дээр сумын ИТХ, Засаг дарга болон ТУЗ-ын дарга, захирал, гишүүд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 21^{1.16}, 21^{1.27}, 77.2.1⁸, 77.2.2⁹, 78.2.1¹⁰ гэсэн заалтуудыг зөрчиж эрх хэмжээний үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

³ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁴ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

⁵ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁶ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ

⁷ Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана

⁸ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах

Цаашид тухайн байгууллагын ашиг алдагдал, өр авлагыг бүрэн барагдуулж ажиллах, өглөгийг нэмэгдүүлэхгүй тал дээр хамтран ажиллаж заавар, зөвлөгөө, үүрэг даалгавар өгч биелэлтийг ханган ажиллах шаардлагатай байна.

Б.3.3 Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнаж, үүрэг даалгавар авч ажиллажээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2019 оны үйл ажиллагааны тайланг сумын ИТХ-д танилцуулж хуралд жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг 89.7, Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 85.4, өмч ашиглалт гэрээний биелэлт 89 хувиар хэрэгжсэн гэж тус тус танилцуулан ажиллажээ.

Тус хурлаар “Тэшиг ус” ОНӨААТҮГ-т үүсэж байгаа өглөг, авлагыг нэмэгдүүлэхгүй, барагдуулах тал дээр арга хэмжээ авч ажиллах, цаашид үйл ажиллагааг өргөжүүлэх тал дээр ажил зохион байгуулж ажил гэсэн үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Аудитаар нийт 30725.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 604.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 21618.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 8502.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж тус тус хүргүүлэн ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.
- “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөг 7368.5 мянган төгрөгийн алдагдалтай тооцоолж батлуулсан.
- ТУЗ-ийн дарга байгууллагын бүтэц орон тоог батлахдаа тогтоолын хавсралтад өөрийгөө сар бүр 950.0 мянган төгрөгөөр цалинжуулж ажиллана гээд орон тоонд оруулж баталсан.
- Байгууллагын дарга ажилчдад нөхөн олговор олгох тухай тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулж 1200.3 мянган төгрөгийн нөхөн олговрын цалин авсан.
- ТУЗ-ын дарга нь 5843.0 мянган төгрөгийн цалин авсан нь ТӨОХЭТӨТ-ийг хэрэгжүүлэх журмын 3.7¹¹дахь заалтыг үндэслэж цалин авч байгаа боловч тус заалтад санхүү, эдийн засгийн байдал ашиг орлогын үзүүлэлтийг харгалзан үзэж цалин урамшууллыг авч болно гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.
- Авлага, өглөгийг нэмэгдүүлж ажилласан, авлагыг дутуу тайлагнасан.
- Гэрээ хийгээгүй газраас нүүрсний таталт хийж, хувь хүний данс руу шилжүүлсэн, ХХОАТ суутган тооцоогүй, нэхэмжлэх баримт дутуу бүрдүүлсэн.
- Бэлэн мөнгө их хэмжээгээр гаргасан, кассын тайлангийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.
- Жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг тайлагнаж ажилласан ч ашиг алдагдлын тооцооллыг үзэхэд өглөгийг 6084.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 110115.7 мянган төгрөгийн өглөгтэй, 18660.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь сумын ИТХ болон Засаг дарга, ТУЗ-ын дарга, захирал, гишүүд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй үр дүн бага, дотоод хяналт сул гэж дүгнэж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:
Нэг: Сумын ИТХ-ын дарга Д.Энхтуяад:

1. Дотоод хяналтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцож ажиллах.

⁹ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх

¹⁰ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

¹¹ Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

Хоёр. Тэшиг сумын Засаг дарга Б.Батсайханд:

1. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын алдагдал болон өр авлагыг бууруулах, ашигтай ажиллах тал дээр хамтран ажиллаж, тодорхой арга хэмжээ авах.

Гурав. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал С.Баярсайхан, нягтлан бодогч Э.Оюун-Эрдэнэ нарт:

1. Үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг алдагдалгүй тооцоолж батлуулах.
2. Худалдан авалтын гэрээ хийсэн газруудаас худалдан авалтыг хийж, ХХОАТ-ыг тооцох талаар гэрээнд тусгаж ажиллах.
3. НББ-ийн тухай болон ТӨОХЭТӨТ-ийг хэрэгжүүлэх тухай журмыг мөрдөж ажиллах.
4. Бэлэн мөнгөний гүйлгээг багасгаж кассын тайланг үнэн зөв тайлагнаж, анхан шатны бүрдэлтийг ханган ажиллаж дотоод хяналтыг сайжруулах.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА

Хавсралт 1

Авлага өглөгийн дэлгэрэнгүй				/төгрөгөөр/
№	Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
1	Ажилчдаас	4919153	2409153	Буурсан
2	Ажилчдаас /2017/	1393357.09	1393357.09	Барагдуулаагүй
3	Хүчит ухаан		226380	Тухайн онд нэмэгдсэн.
4	Батчимэг		34216	
5	Цэцэрлэг		716350	
6	Од буудал		638766	
7	Залман буудал		310831	
8	Эгийн далай		118796	
9	Тэмүүлэн дэлгүүр		47231	
10	Соёлын төв		400	
11	Төрийн банк		1	
12	Тэшгийн буудай		114918	
13	Сүрэнжав		367951	
14	Вансэмбэрүү		41965	
15	Б.Батсайхан		99000	
16	НДХ		154987.7	
17	Татварын хэлтэс		353750.01	
18	ЗДТГ	11719619		Барагдаагүй.
19	Залман дэлгүүр	328820.91		
Нийт авлагын дүн		18360950	7028052.8	
№	Өглөгийн төрөл			
1	Илчит металл	15613780	15613780	Тухайн онд өглөг 6084408.57 төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.
2	Эрэн уул	458650	458650	
3	ЗДТГ		1626846	
4	Цэрэндулам		310000	
5	Мон ажнай ХХК	11183636.36	6330400.36	
6	Бадмаанямбуу ХХК	962587.18	1436587.18	
7	Анд туруун ХХК		28771000	
8	Амарсайхан	1460247.36	2276215.36	
9	Э.Ууганбаяр	135700	0	
10	Булган кашмер	2310000	0	
11	Чамин дэлгүүр		105533	
12	ЭМТ		231000	
13	ХААН банк	22360123	12739420.31	
14	Ажилчдад		1920584.1	
15	Татварт	21783335	37160046.25	
16	НДХ	3114589.85		
17	Хувь хүнд	3103486		
Нийт дүн		104031353.99	110115762.56	